



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 5/71

Хэрлэн сум

Ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.15, 30.1.16, Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.1.8, 38 дугаар зүйлийн 38.1, 38.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр сумын "Энхжин" цэцэрлэгийн эрхлэгч Ө.Нарантуяа, "Бүжинхэн" цэцэрлэгийн эрхлэгч Р.Мөнгөнтуул нарын хөдөлмөрийн гэрээг 2017 оны 3 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн цуцалж, үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.
2. Эрхлэгч нарын ажлыг хүлээлцэх комисс томилон ажиллуулахыг сумын Засаг дарга /П.Чинбат/-д даалгасугай.
3. Эрхлэгч нартай зохих хууль, журмын дагуу холбогдох тооцоог хийж дуусгахыг цэцэрлэгийн нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА